


Дорно дахины номын сан хөмрөгөөс толилуулж байна. Цуврал №1

Монгол Улсын Үндэсний номын сангийн Дорно дахины номын сан хөмрөгт өнөөгийн байдлаар Дорно дахины улс орнуудын түүх соёлын үнэт өв болсон, хятад, манж, япон, солонгос, вьетнам зэрэг таван хэлний 100 гаруй мянган ном хэвлэл хадгалагдаж байдаг ба эдгээрээс онцлох нэг хэсэг бол манай улстай өнгөрсөн хэдэн зуун жилийн турш улс төр, нийгэм, хэл соёлын талаар ойр холбоотой байсан манж Дайчин улс болоод Монголын ард түмний түүхийн эгзэгтэй, чухал үеийн эх сурвалж болж үлдсэн, дахин давтагдашгүй 8000 орчим манж номын сан хөмрөг билээ.

Манж номын баялаг цуглуулгаараа дэлхийд дээгүүрт ордог манай сан хөмрөгт манж хэлээр бүтээсэн түүх шастир, билиг сургаал, хэл шинжлэл, уран зохиол, хууль цаазын бичиг зэрэг одоо цагт олохуйяа бэрх болсон ховор чухаг номнууд хадгалагдаж байгаагаас дээжлэн уншигч түмэндээ цувралаар толилуулж байна.

Нэг. Гүн ухаан, ёс суртахуун, сургаалын бүтээлийн дээжис



Модон барын хэвлэл, 1 дугтуй 4 дэвтэр.

Дөрвөн үндэсний чухал хураангуйн бичиг

Дайчин улсын Фү овогтын эхлэн зохиосныг түүний хөвгүүн Фү Мин Лян эмхэтгэн төгсгөж Энх-Амгалангийн хар луу жил буюу 1712 онд анх хэвлэсэн ба Тэнгэрийн тэтгэсэний улаан барс жил буюу 1746 онд дахин хэвлэжээ.

Энэ бичигт дөрвөн үндэс гэгч нь бичиг сурах нь гэрийг дэгжээх үндэс, хичээнгүй арвигч нь гэрийг засах үндэс, элэгсэг найртай нь гэрийг тэгшлэх үндэс, ёс зүйг дагах нь гэрийг хамгаалах үндэс хэмээн өгүүлжээ.

Хааны бичиж орчуулсан дөрвөн бичиг

Эдгээр нь:

- Урьд хождын их сургуулийн хүнийг сургах хууль, Богдын ном, эрдэмтний шастирын зорилтыг ертөнцөд дахин гэгээн тодорхой болгосон: **Их суртахуй бичиг**

- Күнзийн ач Зи Сэгийн эцэг өвгөдийнхөө “Тэнгэрийн ёс”, “Хүний ёс” хэмээх санааг залган хөгжүүлж хойчийн сурах ардад ухуулан бичсэн: **Хэв дундад бичиг**

- Күнзийн намтрыг өгүүлэн улмаар эртний Хятадын олон улсын хаадын үеийн алдаж эндсэн, онож ухаарсан зэргийг мэргэдийн үгээр ишлэн сургамжилсан: **Шүүмжлэл өгүүлэл**


- Күнз, Янз, Зэнз, Зи Сэ нарын суртлыг уламжлан авсан Мэнзийг өөд болсны дараа шавь нар нь тэмдэглэн хоцорсноо ном болгосон: **Мэнзийн бичиг хэмээх дөрвөн бичиг** юм. Тэнгэрийн тэтгэсэний 20-р /1755/ онд манж, хятад хоёр хэл хавсарган хэвлэжээ. Модон барын хэвлэл, 1 дугтуй 6 дэвтэр.



Хааны бичсэн, орчуулсан засагт ном

Энэ бол эртний хаадын үед зохиогдсон ном бөгөөд хожим Сүн улсын Цай Юаны 5-р онд засвар оруулж 58 бүлэг болгон гаргасан нь одоо хятад хэлнээ буй “Засагт ном” юм.

Эртний хуанди, хаадын сэтгэлийн онол, засгийн онолын бүрдсэн явдлыг тэмдэглэсэн, шууд нэвт болох, холыг мэдэхийг чухал болгосон, нар одны гийх, мөрөн голын урсах адил ертөнцийг засах их сургаал үүнийг Тэнгэрийн тэтгэсэний 25-р /1760/ онд манж, хятад хэлээр хавсарган хэвлэжээ.



Модон барын хэвлэл, 1 дугтуй 6 дэвтэр.



Модон барын хэвлэл, 1 дугтуй 4 дэвтэр.

Хааны бичсэн, орчуулсан зурхайт ном

Эртний Фү Шигийн найман хөллөөс эхлэн үсэг, эх бий болж Жэү улсын Вэн Ванд хүрч ирээд сая “Зурхайт ном”-ыг зохиоход найман хөлөл ба арга билгийн хөгжил буурахуй зүй байдал, тоо хувиралтын сайн муу болох ёсыг ялган салгаж өгүүлсэн ажээ.

Тэнгэрийн тэтгэсэний 30-р /1765/ онд манж, хятад хэлээр хавсарган хэвлэжээ.

Хааны бичсэн, орчуулсан шүлэглэлт ном

Энэ номд эртний Жэү улс болон тэр үеийн олон улсын төр, засаг засаглалын талаар онож алдсан аль нэгийг тоочин гаргаж хойч үеийн хүмүүст сургаал болгожээ.

Анх Эээр засагчийн 11-р /1654/ онд манж хэлнээ орчуулсныг Тэнгэрийн тэтгэсэний 33-р /1768/ онд дахин хянан засаж манж, хятад хэлээр хавсарган хэвлэжээ.




Модон барын хэвлэл, 1 дугтуй 8 дэвтэр.

Хааны бичсэн, орчуулсан ёслолт ном

Энэ номд эртний үеэс манж Дайчин улс хүртэлх үеийн аливаа тахилга, ураг боллоцх, хувцас малгай өмсөх зэрэг үндсэн заншил ёслолыг хураан өгүүлжээ.

Тэнгэрийн тэтгэсэний 48-р /1783/ онд манж, хятад хэлээр хавсарган хэвлэжээ.



Модон барын хэвлэл, 2 дугтуй 30 дэвтэр.



Модон барын хэвлэл, 6 дугтуй 64 дэвтэр.

Хааны бичсэн, орчуулсан шашинт ном

Чүн Чиүгийн үе буюу МЭӨ 721 оны үес анх гарсан ба Тэнгэрийн тэтгэсэний 49-р /1784/ онд манж, хятад хэлээр хавсарган хэвлэжээ.


Лү улсын Ен Гүний тэргүүн оноос Лү улсын Ай Гүний 27-р он хүртэл бүгд 242 жилийн хоорондох Хятадын олон улсын хөгжил буурал, түшмэдийн сайн мууг тоочин тэмдэглэсэн судар ажээ.

Орчуулсан зургаан хэргийн цээрлэл үгийн бичиг

Биеэ залах, гэрээ засах, түшмэл суух, гацаанд суух, хэрэг шийтгэх, хүнийг энэрэн үзэх зэргийн зургаан зүйл явдлаар болгоомжлон явахыг өгүүлсэн энэ номыг Мэн Буу манж хэлнээ орчуулж Түгээмэл элбэгтийн тэргүүн /1851/ онд хэвлэжээ.



Модон барын хэвлэл, 1 дугтуй 4 дэвтэр.



Модон барын хэвлэл, 1 дугтуй 4 дэвтэр.

Орчуулсан ертөнцөд ухуулах чухал үгийн бичиг

Биеэ залж явдлаа засахыг чухал болгон үзүүлсэн энэ номыг Мэн Буу хэмээгч манж хэлнээ хөрвүүлснийг Бүрэнт засагчийн 6-р /1867/ онд хэвлэжээ.